

ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ

*гадамжид суурилсан сургалтын
хөтөлгөө*



Мэргэжлийн боловсрол, сургалтын
3 жилийн ангид зориулав

2024

Энэхүү хөтөлбөрийг БШУ-ны сайдын 2023 оны 06-р сарын 28-ны өдрийн А/278 тоот тушаалд үндэслэн, Монгол дахь Хүүхдийг ивээх сангийн “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” сургалтын хөтөлбөрийг “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар”-т шилжүүлэн боловсруулсан болно.



Дижитал хувилбарт шилжинэ.

ISBN:



©2024 Хүүхдийг Ивээх Сан

Энэхүү сургалтын хөтөлбөр нь Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн өмч бөгөөд худалдаалах болон албан ёсны зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулах, дахин хэвлэхийг хориглоно. Японы нийгмийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэвлэв.

Номын дизайн: **Номун Ерөөл ХХК**

Талархал

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрөөс энэхүү “Энтерпренетшипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын хөтөлбөрийг боловсруулсан төслийн зөвлөхүүдээ гүн талархал илэрхийлье.

Хатагтай **Барбара Фриймэн**

Хувь Хүний Ур Чадвар, Энтерпренершипийн Олон Улсын Зөвлөх

Ноён **Эрдэнэбатын Бат-Орших**

Энтерпренершипийн Үндэсний Зөвлөх

Хатагтай **Пүрэвдоржийн Оюунаа**

Боловсролын Үндэсний Зөвлөх, Боловсролын Үндэсний Зөвлөх Багийн Ахлагч

Хатагтай **Сэдийн Санжаабадам**

Боловсролын Сэтгэл Судлалын Үндэсний Зөвлөх

Хатагтай **Амгалангийн Энхтогтох**

Сургалтын Агуулгын Үндэсний Зөвлөх

Хатагтай **Базарханы Харашаш**

Сургалтын Агуулгын Үндэсний Зөвлөх

ESEL хөтөлбөрийн сургалтад өөрсдийн боловсруулсан видео контентыг үнэ төлбөргүй ашиглах зөвшөөрөл олгож үнэтэй хувь нэмэр оруулсан дараах өгөөмөр сэтгэлтэй байгууллага, хувь хүмүүст гүн талархал илэрхийлж, ажилд нь амжилт хүсье.

WEMAKE - www.wemake.no

Lessons for SEL - www.lessonsforSEL.com

BBC Brainsmart - <http://www.bbc.co.uk/scotland/brainsmart>

Швейцарын Хамтын Ажиллагааны Газар - Залуучуудын Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Төсөл - <https://www.eda.admin.ch/countries/mongolia/en/home/representations/cooperation-office.html>

Хорват улсын CEDRA төрийн бус байгууллага - www.cedra.hr

Лантуун Дохио ТББ - <http://lantuun.mn/lantuuhuu/>

SPROUTS LEARNING Компани - www.sproutsschools.com

Ноён Evelio Pereira - www.epicster.com

Strategyzer AG Компани - www.strategyzer.com

Pinellas захиргааны байгууллага - <http://www.pinellascounty.org/>

Орхон аймгийн Баян-Өндөр сум - www.bayan-undur.mn болон
Жаргалант сумын ЗДТГ <http://www.erdenet.mn/lavlah/organ.php?id=130800005>

Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сан - www.smefund.gov.mn

Мандал Даатгал ХХК - www.mandal.mn

“Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн боловсролын 3 жилийн сургалтад нэвтрүүлэх зорилгоор “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар”-т хөрвүүлэн боловсруулсан ажлын хэсгийн гишүүддээ гүн талархал илэрхийлье.

Д.Адилбиш	БШУЯ-ны МБС-ын хэлтсийн сургалтын хөтөлбөр, үнэлгээний бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагнал хариуцсан ахлах шинжээч
П.Жавзмаа	БШУЯ-ны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын сургалтын хөтөлбөр, агуулга, орчин, хэрэглэгдэхүүн хариуцсан шинжээч
Ж.Мөнхзул	БЕГ-ын МБС-ын байгууллагын багш, удирдах ажилтны хөгжил, менежмент хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн, Зөвлөх зэрэгтэй
Н.Алтанчимэг	БЕГ-ын МБС-ын орчин, хэрэглэгдэхүүн хариуцсан мэргэжилтэн, Тэргүүлэх зэрэгтэй
П.Золзаяа	БЕГ-ын МБС-ын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, Тэргүүлэх зэрэгтэй
Б.Гэрэлмаа	БСҮХ-ийн МБС хариуцсан мэргэжилтэн
Ё.Нямдаваа	ХИС-ийн “Орон нутгийн өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтерпренершипийн боловсрол олгох” төслийн менежер
Т.Гантуяа	ХИС-ийн “Орон нутгийн өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтерпренершипийн боловсрол олгох” төслийн зохицуулагч
Г.Сэлэнгэ	Монгол-Солонгосын политехник коллежийн багш, Тэргүүлэх зэрэгтэй

Талархал

- С.Отгонбаяр** Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн арга зүйч багш, “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” сургалтын чиглүүлэгч багш, Тэргүүлэх зэрэгтэй
- Д.Нямсүрэн** Сүхбаатар аймаг дахь МБС-ийн багш, “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” сургалтын чиглүүлэгч багш
- Б.Отгонбаатар** Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь МБС-ийн багш, Заах аргач зэрэгтэй, “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” сургалтын чиглүүлэгч багш
- Д.Болор-Эрдэнэ** Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын политехник коллежийн багш
- Г.Оюунцэцэг** Барилгын Политехник коллежийн багш, Заах аргач зэрэгтэй
- Б.Солонго** Налайх политехник коллежийн багш

Товчилсон үгийн жагсаалт

БГА

Багшийн гарын авлага

БЕГ

Боловсролын ерөнхий газар

БСҮХ

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

БШУЯ

Боловсрол шинжлэх ухааны яам

ГЦХ

Гүйцэтгэлийн цар хүрээ

ГШҮ

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

МБС

Мэргэжлийн боловсролын сургууль

МБСС

Мэргэжлийн боловсрол сургалтын стандарт

МБТБС

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт

МТ

Мэдээлэл технологи

ПК

Политехник коллеж

СГА

Суралцагчийн гарын авлага

ХАБЭА

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

ЧН

Чадамжийн нэгж

ЧЭ

Чадамжийн элемент

ЧСС

Чадамжид суурилсан сургалт

ЧССХ

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр

ХИС

Хүүхдийг ивээх сан

ESEL

Entrepreneurship-focused socio-emotional learning

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр

1.	Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	8
1.1	Үндэслэл, ач холбогдол	8
1.2	Хөтөлбөрийн зорилго	9
1.3	Хөтөлбөрийн суралцахуйн үзэл баримтлал	11
1.4	Сургалтын арга зүй	14
2.	Суралцахуйн үр дүн	16
3.	Сургалтын зохион байгуулалт	21
3.1	Сургалтын зохион байгуулалтын хэлбэр	21
3.2	Сургалтын төлөвлөгөө	21
3.3	Танхимын сургалтын үйл ажиллагаа	22
3.4	Танхимын бус сургалтын үйл ажиллагаа	22
3.5	Сургалтын менежер, аргазүйчдэд өгөх зөвлөмж	23
4.	Сургалтын агуулгын тойм	24
4.1	Чадамжийн нэгжийн жагсаалт	26
4.2	“Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” чадамжийн нэгжийн бүтэц	26
4.3	“Энтерпренершип ур чадвар хөгжүүлэх” чадамжийн элементийн төлөвлөгөө	30
4.4	“Энтерпренершипийн оролцогч талуудыг тодорхойлох” чадамжийн элементийн төлөвлөгөө	32
4.5	“Энтерпренершипийн хэрэгцээ, боломжийг илрүүлэх” чадамжийн элементийн төлөвлөгөө	34
4.6	“Энтерпрайз төсөл боловсруулах” чадамжийн элементийн төлөвлөгөө	37
4.7	“Энтерпрайз төслийн хэрэгжилтийн үйл явц, үр дүнг тандан судлах” чадамжийн элементийн төлөвлөгөө	40
4.8	“Шинэ төсөл боловсруулах” чадамжийн элементийн төлөвлөгөө	42
5.	Агуулгын дэлгэрэнгүй төлөвлөлт	44
6.	Сургалт зохион байгуулахад тавих шаардлага	51
7.	Үнэлгээ	55
8.	Ашигласан материалын жагсаалт	58

1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Үндэслэл, ач холбогдол

Энтерпренершипийн талаарх ойлголт өргөн хүрээтэй хэдий ч хувь хүний ур чадварыг хөгжүүлэх ESEL сургалтын хүрээнд Европын холбооноос тодорхойлсон цогц чадамж болох талаас нь авч үзлээ. “Энтерпренершип гэдэг нь бусдад зориулсан үнэт зүйл бий болгох замаар тодорхой хэрэгцээг хангах боломж болон санааг хэрэгжүүлэх чадавх юм. Энэ үнэт зүйл нь нийгмийн, соёлын, санхүүгийн болон бизнесийн шинж чанартай байж болдог” (European Union, 2018).

Энэ тодорхойлолтыг ашиглах болсон шалтгаан нь боловсрол, сургалтын орчинд нэгэнт танил болсон сонгон суралцах хичээл, хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөр, насан туршдаа суралцахуй зэрэг ойлголтод тулгуурлан, багш нар энэ хичээлээр суралцагчдынхаа хувь хүний ур чадвар (нийгэм-сэтгэл хөдлөлийн), сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой гэж үзсэнтэй холбоотой.

Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалт нь:

Нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцахуй
21 дүгээр зууны ур чадвар
Энтерпренершип боловсрол
Нийгмийн инновацын боловсрол

гэсэн 4 үзэл баримтлалд үндэслэнэ. Сүүлийн жилүүдэд эдгээр үзэл баримтлалыг тус тусад нь салангид байдлаар хэрэглэхээс илүүтэйгээр хүүхэд залуучуудыг амжилттай суралцах, ажиллах, амьдрахад шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага (сэтгэлгээ)-ын цогц гэж үздэг болсон байна.

Энэхүү сургалт нь энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх **МЭДЛЭГ, ЧАДВАР, СЭТГЭЛГЭЭ** гэсэн 3 үндсэн бүрэлдэхүүнтэй.

Сургалтад мэргэжлийн боловсролын 3 жилийн хөтөлбөрөөр суралцагчид хамрагдах бөгөөд тэднийг сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, сэдэл тэмүүллийг төрүүлэх нь энэ сургалтын арга зүйн гол шаардлага юм. Суралцагчийн хандлага, итгэл үнэмшил, сэтгэл хөдлөлд чиглэсэн хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг энтрепренершипд тулгуурлан зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд сургалт нь тэдний сонирхлыг төрүүлэх, өөртөө итгэх итгэл үнэмшлийг бий болгох, хөгжүүлэх зорилго бүхий бие даасан болон багийн үйл ажиллагаатай.

Хэрэв суралцагчдыг сэдэлжүүлж чадвал тэд бүтээлчээр сэтгэх, асуудлыг шийдэх, багаар ажиллах, шинэ ухагдахуун, стратеги, техникийг сурахад нээлттэй хандаж эхэлдэг.

1.2 Хөтөлбөрийн зорилго:

Энэхүү сургалт нь мэргэжлийн боловсролын суралцагчид бие дааж ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах **мэдлэг, чадвар, сэтгэлгээг** хөгжүүлэх зорилготой.

Сургалтад хамрагдсанаар суралцагч дараах мэдлэгээ хөгжүүлнэ. Үүнд:

- ✓ Энтрепренершипийн суурь мэдлэг
- ✓ Бизнес төлөвлөлтийн мэдлэг
- ✓ Санхүүгийн мэдлэг
- ✓ Нөөцийг зохистой хуваарилах, боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг
- ✓ Дижитал мэдлэг

Сургалтад хамрагдсанаар суралцагч дараах чадвараа хөгжүүлнэ. Үүнд:

- » Өөрийгөө таньж мэдэх, ухамсарлах, сэтгэл хөдлөлөө тодорхойлох, стрессийг удирдах, цагаа зөв зохицуулах, төлөвлөх, өөрийн давуу тал, хүчийг таньж мэдэх
- » Бүтээлч, инновацын ур чадвартай болох, шинэлэг боломжуудыг илрүүлэх, шинэ санаа гаргах, түүнийгээ турших

- » Харилцааны янз бүрийн нөхцөл байдалд бусадтай зөв харьцах, ойлголцох, анхааралтай сонсох, асуулт асуух, өөрийн санаагаа тайлбарлах
- » Багаар ажиллах, хамтын зорилгоо тодорхойлох, хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх, бүтээлчээр зөвшилцөх
- » Нийгэм, соёлын ялгаа, нийтлэг байдлыг таньж мэдэх, ухамсарлах, бусдын байр сууринд өөрийгөө тавих, олон талт өнцгөөс харах
- » Шүүмжлэлт сэтгэлгээтэй байх, мэдээлэл цуглуулах, учир шалтгааныг эргэцүүлэх, ёс зүйтэй шийдвэр гаргах, эргэцүүлэн тунгаах

Сургалтад хамрагдсанаар суралцагч дараах сэтгэлгээгээ хөгжүүлнэ.

Үүнд:

- » Бэрхшээлээс үл хамааран тодорхой хүчин чармайлт гаргаж, оролдлого хийх
- » Алдаанаас суралцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх
- » Өөрийгөө сорих, зогсолтгүй урагшлах, шантрахгүй байх
- » Аливаад нээлттэй байх, сониучаар хандах, асуулт асуудаг байх
- » Санаагаа ажил хэрэг болгох, бэрхшээлд бууж өгдөггүй байх, санаачилга, сэдэл тэмүүлэлтэй хандах
- » Эргэлзээтэй, тодорхойгүй нөхцөл байдлыг зохицуулах, эрсдэлийг удирдах



1.3 Хөтөлбөрийн суралцахуйн үзэл баримтлал

ЧСС-ын энэхүү хөтөлбөр нь энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын үндсэн бичиг баримтын нэг юм. Тус хөтөлбөрийн хүрээнд сонгож авсан мэдлэг, чадвар, сэтгэлгээ нь энтрепренершипийн боловсролыг хөгжүүлэхэд зайлшгүй шаардагдах ур чадвар учраас сургалтын үйл ажиллагаа, даалгавар, дасгал нь энтерпрайзын үйл ажиллагаагаар тодорхойлогдсон. Тиймээс энтрепренершипийн боловсролын онол, үзэл баримтлал, экспансив суралцахуйн онолыг тус хөтөлбөрийн онол, арга зүйн үндэс болгон авч үзлээ.

Энтрепренершипийн боловсролын талаар хийгдсэн судалгаагаар энэ нь уламжлалт сургалтаас нэлээд өөр юм. Учир нь энтрепренершипийн сургалт илүү шинэлэг, инновацлаг бөгөөд суралцагчдын үйл, идэвхтэй үйл ажиллагаанд суурилсан (Mwasalwiba, 2010), бодит асуудлыг шийдэхэд чиглэсэн байдаг. Энэ сургалт нь олон төрлийн хичээлийн мэдлэг, ур чадварын огтлолцлоор тодорхойлогддог, агуулгын хувьд интеграцчилагдсан, суралцагчдын хамтын ажиллагаа, зөвшилцөл, шийдвэр гаргалтыг нэлээд их шаарддаг, төсөлт хэлбэрийн даалгавартай, сурах үйлийн явцад илүү ач холбогдол өгч ханддаг (Lackeus, 2015).

Данийн эрдэмтэн, судлаач Иллерис суралцахуйн 16 онолыг судалсан бөгөөд цөөн хэд нь энтрепренершипийн сургалтад хэрэглэх боломжтой гэж дүгнэсэн байдаг ба энэ дундаас хамгийн тохиромжтой нь экспансив суралцахуйн онол (Leont'ev, 1978; Engeström, 1987) гэж үзжээ.

Экспансив суралцахуйн онолын хөгжүүлэгчээр Финландын Хелсинкийн их сургуулийн эрдэмтэн Энгерстром зүй ёсоор тооцогддог. Түүний тодорхойлсноор энэ онол нь суралцагчид ямар нэг үйлийн системийн үндсэн ухагдахууныг дахин тодорхойлох, тухайн үйлийн өмнөх хэлбэрээс илүү өргөн хүрээний боломжийг багтаах үйлийн сэдэл бий болгох замаар хамтаараа хувирган өөрчлөх эсвэл өргөтгөх үйл явц юм (Engeström 2003, pp. 30-31). Энэ нь нийгмийн тодорхой хэсгийн соёл, итгэл үнэмшлийг шинэ соёл, үнэт зүйл болгон өөрчлөх эсвэл илүү өргөтгөн цоо шинээр бүтээх, тэднийг бусадтай олон янзын байдлаар хамтран суралцах боломжийг олгодог байна. Энэ нь илүү шинэлэг, инновацлаг, хүмүүсийн олон янзын туршлага, дадлаар тодорхойлогддог ба суралцагчдад хараахан “бий болоогүй”, урьдчилан мэдэх боломжгүй тэр нөхцөл байдалд ажиллаж, амьдрах ур чадварыг хөгжүүлдэг. Энэ утгаараа суралцагчдад эргэлзэх, асуулт асуух, нэгэнт тогтсон жишиг, нормд шүүмжлэлтэй хандах, илүү үр дүнтэй байдлаар өөрчлөх гэж оролдох, олон талт байдлаар асуудалд хандах, асуудлын учир шалтгаан, үр дагаврыг

эргэцүүлэх, шинэ загвар, практикийг санал болгох гэх мэт суралцахуйн “хэвшмэл бус” үйл, сэтгэлгээг дэмжиж өгдөг тодорхой цикл бүхий сурах үйл ажиллагаатай үзэл баримтлал юм.

Экспансив суралцахуйн онолоор суралцахуй гэдэг нь дараах байдлаар тодорхойлогдоно.

1.

Ямар нэг зүйлийг танин мэдэхүйн арга хэрэгслээ ашиглан утга учиртайгаар бүтээдэг үйл явц

2.

Суралцагчийн харилцан яриа, оролцоо, хамтын ажиллагааны үр дүнд явагддаг үйл явц

3.

Одоо байгаа практикийн асуудлаа эргэж харж асуух, эргэлзэх, шүүмжлэлт байр сууринаас хандах замаар илүү шинэ санаа, зан үйлийг бүтээдэг үйл явц

Энэ онолоор суралцахуй нь дараах 7 үйл ажиллагаагаар явагдах бөгөөд эдгээр нь суралцагчдад зөвхөн энтрепренершипийн тухай мэдлэг олгохоос илүүтэйгээр түүнийг бий болгож хөгжүүлэхэд шаардагдах илүү шинэлэг, өргөн хүрээтэй мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжийг олгодог байна.



1. Эхлээд одоо байгаа практик эсвэл үзэл санааны талаар асуулт асуух, шүүмжлэлтэй хандах, магадгүй хүлээн зөвшөөрөхгүй байх замаар шинэ мэдлэг, чадвар, зан үйл бүтээх суралцахуйн хэрэгцээг тодорхойлох
.....
2. Нөхцөл байдлын талаар “яагаад” гэж асуух, тайлбарлах замаар учир шалтгааны дүн шинжилгээ хийх. Энэ нь хоёр талтай үйл ажиллагаа юм. Нэгдүгээрт тухайн нөхцөл байдал өдий хүртэл яаж бий болсон буюу түүхэн хөгжил талаас нь харах, хоёрдугаарт тухайн нөхцөл байдлын өдөр тутмын практик болон түүнийг хэрэгжүүлэгч хүмүүсийн зохицуулалтад илэрч байгаа зөрчлийн талаарх эмпирик нотолгоо шинжилгээ хийх
.....
3. Тухайн нөхцөл байдал дахь практик үйлийн учир шалтгааныг илрүүлснээр шинэ загвар, санаа боловсруулан дэвшүүлэх буюу нээлт хийх
.....
4. Шинэ загвар, санаагаа практикт туршиж сорих, түүнийхээ хязгаарлагдмал байдал, боломж, үр өгөөжийг үнэлж дүгнэх замаар сайжруулах
.....
5. Шинэ загвар, санаагаа практикт хэрэгжүүлж, илүү сайжруулах
.....
6. Шинэ загвар, санаа, түүнийг бий болгож, хэрэгжүүлсэн үйл явц, үүнээс юу сурсан талаараа эргэцүүлж, цаашид юу сурах шаардлагатайгаа тодорхойлох
.....
7. Үйл явцаа нэгтгэн дүгнэж, эцэслэн боловсруулсан загвар, санаагаа практикт тууштай хэрэглэх, бусдад санал болгох, түгээн дэлгэрүүлэх

Ийм учраас энтрепрнершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтыг эдгээр 7 үйл ажиллагаат циклээр зохион байгуулж, удирдахаар төлөвлөсөн.

Экспансив суралцахуйн үйл ажиллагааг суралцагчдын хамтын үйл ажиллагаа, зөвшилцөл, шийдвэр, эрэлхийлэлд тулгуурлан явуулах нь шинэлэг зүйлийг, зан үйлийг бүтээхэд чухал үр дүнтэй. Судлаачдын үзэж байгаагаар суралцагчид хамтран аливаа төслийг гүйцэтгэх явцдаа суралцдаг арга зүй нь энтрепрнершип сургалтад хамгийн тохиромжтой бөгөөд суралцагчид өөрийн сурах үйлээ өөрөө удирдан суралцах нь энэ арга зүйн хамгийн цөм зарчим юм.

Энтрепелнершип сургалтад багшийн үүрэг хамгийн чухал байдаг учраас багш өөрөө шинийг санаачлагч, бүтээгч, энтрепелнер сэтгэлгээтэй, асуудлыг шийдэх, хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай, оновчтой ашигладаг энтрепелнерүүд байх нь энэ сургалт амжилттай байх үндэс юм (European Commission, 2014; Heinonen & Poikkijoki, 2006; Peltonen, 2015).

1.4 Сургалтын арга зүй

Экспансив суралцахуйд суралцагчид асуудалд шүүмжлэлт байр сууринаас хандаж, түүнийг шийдэх шинэ санаа боловсруулах, турших, сайжруулах, хөгжүүлэх боломжийг тодорхойлоход хамтран хүчин чармайлт гаргадаг учраас энэ суралцахуйг удирдан чиглүүлэх, хөтлөхөд төсөлд суурилсан арга зүй хамгийн тохиромжтой.

Төсөлд суурилсан арга зүй нь динамик шинж чанартай, уян хатан байдаг учраас танхимын болон танхимын бус сургалтын орчин шаарддаг. Суралцагчид төсөл хэрэгжүүлэх явцдаа тулгамдсан асуудал, сорилтыг шийдвэрлэхийн тулд загварчлах, асуудал шийдэх, шийдвэр гаргах, эрэл хайгуул хийх зэрэг цогц даалгавар гүйцэтгэх хэрэгтэй болдог. Бие даасан ажил, багийн үйл ажиллагаанд нэлээдгүй хугацааг зарцуулах бөгөөд үүний үр дүнд тодорхой бүтээгдэхүүн, илтгэл, үзүүлэн, гүйцэтгэл гарч байдгаараа бусад сургалтаас давуу талтай. Сургалтын үед төслийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад үнэлгээ тогтмол хийж, ахиц дэвшлийг харах, ажиглах, түгээх боломжтой байдаг. Төсөлд суурилсан сургалтын бас нэг онцлог нь бодит амьдрал, орчны асуудлыг шийдэх боломжит шийдлүүдийг хайдагт орших бөгөөд энэ нь суралцагчдын сонирхол, сэдэл тэмүүллийг төрүүлж чаддаг.


Төсөлд суурилсан сургалтын хамгийн чухал шинж чанар бол багш шууд заахаас илүү чиглүүлэх, хамтран суралцах, эргэцүүлэн дүгнэх зэрэг насанд хүрсэн хүний суралцдаг арга барилыг шаарддаг. Төсөлд суурилсан сургалт нь судалгаанд суурилсан сургалтын арга зүй, суралцагчдын идэвхтэй оролцоо, өндөр чанартай гүйцэтгэлийг шаарддаг. Эдгээр нь дараах бүрэлдэхүүнтэй.

- Бэрхшээлтэй асуудал, асуултуудыг тодорхойлох
- Шийдэл, хариултыг тасралтгүй эрэлхийлэх
- Бодит орчин, бодит амьдралд суурилах
- Сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг хэрэглэх

- Судлагдахууны интеграцийг хангах
- Суралцагчдын дуу хоолой, сонголтууд нээлттэй байх
- Бодит хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгохыг зорих
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар шүүмж сонсож, эргэцүүлэх, улмаар түүнийг сайжруулах явцын болон төгсгөлийн үнэлгээ хийх

Төсөлд суурилсан арга зүйгээр сургалтыг удирдан чиглүүлэхэд ямар төсөл сонгох вэ гэдэг чухал асуудал байдаг. Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрт төслийн санаа олох, боловсруулах, хэрэгжүүлэх, сайжруулах аргачлалыг боловсруулсан тул төдийлөн бэрхшээл гарахгүй.



Төсөлд суурилсан сургалтад багийн гишүүдийн тоо их чухал. Ихэнх төслийн хувьд нэг баг 4 суралцагчаас бүрдэх нь чиг үүргээ шударга, тэнцвэртэй хуваарилах, өөрийн хувь хүний ур чадвараа бусдад дулдуйдалгүйгээр хөгжүүлэх боломжийг олгодог. Баг бүрдүүлэх хэд хэдэн техникийг ашиглаж болох ба эдгээрийн тухай “Багшийн гарын авлага”-аас үзнэ үү?



2. СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН:

Энэхүү хөтөлбөрөөр суралцагчийн дараах МЭДЛЭГ, ЧАДВАР, СЭТГЭЛГЭЭ-г хөгжүүлнэ. Үүнд:

А. Мэдлэг: Энтрепренершипийн суурь, санхүү, нөөцийг зохистой хуваарилах, боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дижитал мэдлэг гэсэн 5 мэдлэгийн хүрээг сонгон авсан. Мэдлэгийн хүрээ тус бүрээр суралцагчид тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийн тулд доорх суурь ойлголтуудыг эзэмшинэ.

	Мэдлэгийн хүрээ	Суурь ойлголт
1	 Энтрепренер- шипийн суурь мэдлэг	<ul style="list-style-type: none"> • Энтрепренершипийн талаарх ойлголт, нийгмийн болон бизнесийн энтрепренершип, тухайн орон нутаг дахь түгээмэл жишээ • Энтрепренерийн зайлшгүй эзэмшсэн байх ур чадвар, онцлог, орон нутаг дахь энтрепренерийн зарим жишээ • Энтрепренершипийн арга замууд, оролцогч талууд, орон нутаг дахь онцлог • Шинэлэг бизнесийн санаанууд, нийгмийн энтрепренершипийн боломжууд
2	 Бизнес төлөвлөлтийн мэдлэг	<ul style="list-style-type: none"> • Бизнесийн зорилгоо хэрэгжүүлэх шаардагдах нөөцийг тодорхойлох талаарх үндсэн ойлголт • Санхүү, хүний нөөц, үйл ажиллагаа, маркетинг гэх мэт бизнесийн олон янзын салбарын талаарх ойлголт, орон нутгийн жишээ • Бизнесийн загвар, бизнес төлөвлөгөө, төслийн хураангуй, зорилго ба хүрэх үр дүн, бүтээгдэхүүн, үйлчилгээний концепц, нөөц (түүхий эд, материал, санхүү, хүний нөөц), зах зээлийн шинжилгээ, маркетингийн стратеги, үйл ажиллагааны менежмент, засаглалын бүтэц, эрсдэлийн шинжилгээ, санхүүгийн төлөвлөгөөний талаарх ойлголт, зарим жишээ

3	 <p>Санхүүгийн мэдлэг</p>	<ul style="list-style-type: none"> • Мөнгө, орлого, зарлага, өртөг зардал, төсөв, банк, зээл гэх мэт санхүүгийн суурь ойлголт • Санхүүгийн ухаалаг шийдвэр гаргах, зардал тооцох, төсөв хийх, зөв зарцуулах, хадгалах зуршилтай болох үндсэн ойлголт • Засгийн газрын тусгай сангууд, төрийн бус байгууллагын буцалтгүй тусламж, арилжааны банкны хөнгөлөлттэй зээл гэх мэт санхүүгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл
4	 <p>Нөөцийг зохистой хуваарилах, боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг</p>	<ul style="list-style-type: none"> • Төслийн санаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, техник, дижитал нөөцийг тодорхойлох, хуваарилах, удирдах суурь ойлголт • Хязгаарлагдмал нөөцийг хамгийн оновчтой, үр ашигтайгаар ашиглах талаарх ойлголт • Баг хамт олон бусад оролцогч талуудыг татан оролцуулах арга, туршлага • Бизнес эхлэх, хөгжүүлэх, өргөжүүлэхэд шаардлагатай худалдаа арилжааны мэдлэг
5	 <p>Дижитал мэдлэг</p>	<ul style="list-style-type: none"> • Дижитал тоног төхөөрөмж, компьютер ашиглах мэдлэг • Түгээмэл хэрэглээний программ ашиглах мэдлэг • Мэдээлэл, харилцааны аппликейшн ашиглах мэдлэг • Цахим мэдээлэл авах, сүлжээний талаарх ойлголт

Б. Чадвар: Энэ хичээлээр суралцагчдын өөрийгөө ойлгох, танин мэдэх, нийгэм соёлын орчлыг танин мэдэх, бүтээлч байдал, инновац, харилцах, багаар ажиллах, тунгаан бодох гэсэн 6 үндсэн ур чадварыг хөгжүүлнэ.

	Бүлэг чадвар	БҮРЭЛДЭХҮҮН ЧАДВАР
1	ӨӨРИЙГӨӨ ОЙЛГОХ ТАНИН МЭДЭХ	<ol style="list-style-type: none"> 1. Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх 2. Сэтгэл хөдлөлөө ойлгох, тодорхойлох 3. Сэтгэл хөдлөлөө удирдах 4. Стрессээ удирдах 5. Өөрийгөө бодитоор үнэлж дүгнэх (Сул болон давуу талаа мэдэх)
2	НИЙГЭМ СОЁЛЫН ОРЧЛЫГ ТАНИН МЭДЭХ	<ol style="list-style-type: none"> 6. Бусдын байр сууринд өөрийгөө тавьж үзэх 7. Ялгаатай байдал үзэл бодлыг ойлгон хүндэтгэлтэй хандах 8. Бусдыг хүндлэн ёс зүйтэй үйлдэл хийдэг байх (Бусад суралцагчдын нийгмийн байдал, эд хэрэглэлийн талаар зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй байх гэх мэт) 9. Аливаа зүйлийг олон талын өнцгөөс харах 10. Үр дагаврыг тооцоолон ёс зүйтэй шийдвэр гаргах
3	БҮТЭЭЛЧ БАЙДАЛ, ИННОВАЦИЙГ БИЙ БОЛГОХ	<ol style="list-style-type: none"> 11. Боломжийг илрүүлэх 12. Шинэ санаа эрэлхийлэх, олох 13. Илрүүлсэн боломжоо үнэлж дүгнэх, төсөөлөх 14. Алсын хараагаа тодорхойлох 15. Гаргасан санаагаа турших

4	ХАРИЛЦАХ	<p>16. Бусдыг анхааралтай сонсох</p> <p>17. Асуулт асуух</p> <p>18. Хариултыг ойлгох (Хариултыг бүрэн гүйцэт сонсох)</p> <p>19. Өөрийн санаа бодлоо бусдад ойлгомжтой , тодорхой илэрхийлэх</p> <p>20. Аман болон аман бусаар санаа бодлоо илэрхийлэх (Биеийн хэлэмжийг зөв зохистой ашиглах, ярианы болон бичгийн ур чадвараа сайжруулах)</p>
5	БАГААР АЖИЛЛАХ	<p>21. Хамтын зорилгоо тодорхойлох</p> <p>22. Хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх</p> <p>23. Нөөцийг хуваарилах</p> <p>24. Бусдын санал зөвлөмжийг хүлээн авах болон бусдад санал зөвлөгөө өгөх</p> <p>25. Зөрчлийг бүтээлчээр зөвшилцөх</p>
6	ТУНГААН БОДОХ	<p>26. Мэдээлэл цуглуулах</p> <p>27. Учир шалтгаанд дүн шинжилгээ хийх</p> <p>28. Дасан зохицох</p> <p>29. Ёс зүйтэй шийдвэр гаргах (Зөв бурууг эргэцүүлэн, тогтвортой байдлыг эрхэмлэх)</p> <p>30. Эргэцүүлэн тунгаах</p>



В.Сэтгэлгээ: Сургалтын явцад суралцагчийн **ӨСӨЛТИЙН** болон **ЭНТРЕПЕНЕР** сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой.

Төрөл	СЭТГЭЛГЭЭ
<p>ӨСӨЛТИЙН СЭТГЭЛГЭЭ</p>	<p>ESEL хөтөлбөрийн хүрээнд өсөлтийн сэтгэлгээг оролдлого ба хүчин чармайлт, алдаанаасаа суралцах, тууштай байдал гэсэн 3 бүрэлдэхүүний хүрээнд тодорхойлсон. Энэ нь (1) ур чадвар нь төрөлхийн биш бөгөөд харин шаргуу хөдөлмөр, практикийн үр дүнд хөгждөг, (2) алдаанаас суралцах нь өөрийн чадварыг сайжруулах, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэсэн санаа юм.</p> <p>Суралцагчид хэчнээн хэцүү асуудал тулгарсан ч тодорхой хүчин чармайлт гаргаж, оролдлого хийснээр илүү амжилтад хүрч болно гэдгийг сурна. Алдаа гаргах нь ухаан муутай гэсэн үг биш, хөгжих үйл явцын нэг хэсэг гэдгийг ойлгож, өмнөө тавьсан хүсэл мөрөөдөл, зорилгодоо хүрэхийн тулд өөрийгөө сорьж, бэрхшээлийн өмнө бууж өгдөггүй байхад суралцана.</p>
<p>ЭНТРЕПЕНЕРШИП СЭТГЭЛГЭЭ</p>	<p>ESEL хөтөлбөрийн хүрээнд энтрепренершип сэтгэлгээг сониуч байх, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдлыг зохицуулах чадавхтай байх гэсэн 3 бүрэлдэхүүний хүрээнд тодорхойлсон. Энэ нь (1) саад бэрхшээл тулгарсан ч санаачилга гаргаж, сэдэл тэмүүлэлтэй байх нь таныг урагшлуулж, зорилгодоо хүрэхэд тусалдаг (2) сониуч байх, эрсдэлийг зохицуулах, аливааг оролдож үзэх нь суралцах, бизнес эрхлэх, ажил хайх, сайхан амьдрахын алинд ч олон боломжийг нээж өгдөг гэсэн санаа юм.</p> <p>Мөн, шинэ санаа олж, туршдаг, нээлттэй сэтгэдэг, асуулт асуудаг болж сурахад нь суралцагчдад тусална. Түүнчлэн, суралцагчид хэрхэн санаагаа ажил хэрэг болгох, хүмүүсийг эгнээндээ нэгтгэх, бэрхшээл тулгарсан ч урам зоригтой байх, эргэлзээтэй, тодорхойгүй нөхцөл байдлыг хэрхэн зохицуулахад болон эрсдэлийг удирдахад суралцана.</p>

3. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Зохион байгуулалтын хэлбэр:

Сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн боловсролын 3 жилийн сургалтын төлөвлөгөөнд заасан улиралд хэрэгжүүлнэ.

Сургалт үргэлжлэх нэгж хугацааг 40 минутаар тооцно. Сургалтын зохион байгуулалтын хувьд танхимын ба танхимын бус гэсэн хэлбэртэй байна.

Танхимын сургалт нь онолын болон дадлагын сургалтын 54 цаг, танхимын бус (бие даасан, төсөлт ажил) сургалт нь 36 цаг, нийт 90 цаг байна.

Танхимын бус сургалтын хугацааг багшийн зөвлөгөө, санал өгөх, төслийн үйл явцыг чиглүүлэхэд зарцуулах хугацаагаар тооцсон бөгөөд зарим нөхцөлд суралцагч 36 цагаар хязгаарлагдалгүйгээр суралцах боломжийг бүрдүүлнэ.

3.2 Сургалтын төлөвлөгөө:

№	Чадамжийн нэгж (судлагдахуун)-ийн нэр	Нийт цаг	Танхимын сургалтын цаг		Танхимын бус сургалтын цаг	1 дэх жил		2 дахь жил		3 дахь жил	
			Онол	Дадлага		I	II	III	IV	V	VI
						18	18	9	9	18	18
1	Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх	90	18	36	36			4	3		
	Онол, дадлагын сургалтын цагийн харьцаа (хувиар)		20:80								

3.3 Танхимын сургалтын үйл ажиллагаа

Суралцагчийн бие даан болон багаар ажиллах анги танхим, ширээ сандлын зохион байгуулалтыг оновчтой төлөвлөнө. Сургалтыг танхимд зохион байгуулахаас гадна танхимын бус орчинд явуулна. Танхимаас гадуурх үйл ажиллагааг явуулах байр, боломж, нөхцөл чухал юм.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах хүмүүстэй хамтран ажиллах зорилгоор сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулахад анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Аж ахуй байгуулж, ажиллуулж байгаа хүмүүс
- Аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлж буй хүмүүс (Санхүүч, бизнесийн, төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөл гэх мэт)
- Энтрепренершип ур чадварыг эзэмшсэн хүмүүс (Асуудлыг боломж болгосон шинийг санаачлагч, зохион бүтээгч, маркетингийн мэргэжилтнүүд гэх мэт)
- Багш нь сургалтын хөтөлбөрийн “Агуулгын дэлгэрэнгүй төлөвлөлт” хэсгийн ээлжит хичээлийн хугацааг агуулгын өөрчлөлт гаргахгүйгээр 15-20%-ийн өөрчлөлт хийж, төлөвлөн орж болно.

3.4 Танхимын бус сургалтын үйл ажиллагаа

Сургалтын явцад багш, сургалтын байгууллагын удирдлага, сургалтын алба танхимын болон танхимын бус үйл ажиллагааг хамтран зохион байгуулна.

Танхимын бус сургалтын үйл ажиллагаанаас өмнө багшийн өгсөн даалгавар, төслийг суралцагчид багаар гүйцэтгэх бөгөөд багийн ажлын төлөвлөлт хийх, ажлаа хуваарилах, танхимаас гадуур ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зэрэгт дээрх хүмүүс суралцагчдад тусална. Мөн төсөл, даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ. Ялангуяа сургалтаас гадуурх багийн ажил, төсөлт ажлыг гүйцэтгэхэд эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг бодит нөхцөлд буулгах, хэрэглэхэд түлхүү анхаарах хэрэгтэй.

Танхимаас гадуур гүйцэтгэх ажлын удирдамжийг суралцагчийн гарын авлагад дэлгэрэнгүй тусгасан тул суралцагч урьдчилан танилцсан байх шаардлагатай.

3.5 Сургалтын менежер, арга зүйчдэд өгөх зөвлөмж

- Сургалтыг удирдах багшийн цагийн хуваарилалтыг хийхдээ сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан багшийг сонгоход анхаарна.
- Танхимын бус 36 цагийн агуулгыг сургалтын төлөвлөгөөний улирлын хуваарилалтад оруулан тооцсон тул багшийн цагийн ачаалалд танхимын цагаар тооцно.
- ЧСС-ын хөтөлбөрийг багшийн гарын авлага, суралцагчийн гарын авлага, бусад хэрэглэгдэхүүний хамт багцаар боловсруулсан тул багшийг сургалтын багцыг бүрэн ашиглахад зөвлөн чиглүүлж, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.
- ЧСС-ын хөтөлбөрийн “Агуулгын дэлгэрэнгүй” хэсэгт чадамжийн элементийн хүрээнд багшийн болон суралцагчийн гарын авлага хоорондоо хэрхэн уялдах болон сургалтын цагийг ГШҮ бүрээр тодорхой заасан. Багшийн болон суралцагчийн гарын авлагад ээлжит хичээл бүрийн дасгал, төлөвлөлт, сургалтыг хэрхэн зохион байгуулах, суралцагчийг хэрхэн чиглүүлэх талаар дэлгэрэнгүй оруулсан тул багш нар ээлжит хичээлийн төлөвлөлт боловсруулах шаардлагагүй.
- ЧСС-ын хөтөлбөрийн маягт 3-т заасан материал, түүхий эдийн жагсаалтын дагуу сургалтын бэлтгэл хангахад багшид дэмжлэг үзүүлнэ.



4. СУРГАЛТЫН АГУУЛГЫН ТОЙМ

Сургалтын агуулга нь суралцагчид эзэмшүүлэхийг зорьж буй МЭДЛЭГ, ЧАДВАР, СЭТГЭЛГЭЭГЭЭР тодорхойлогдоно. Чадамжийн нэгж нь дараах чадамжийн элементүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Энтрепренершип ур чадвар хөгжүүлэх
2. Энтрепренершипийн оролцогч талуудыг тодорхойлох
3. Энтрепренершипийн хэрэгцээ, боломжийг илрүүлэх
4. Энтерпрайз төсөл боловсруулах
5. Энтерпрайз төслийн хэрэгжилтийн үйл явц, үр дүнг тандан судлах
6. Шинэ төсөл боловсруулах

Сургалт нь дээрх чадамжийн элемент тус бүрийн дагуу зохион байгуулагдах ба экспансив суралцахуйн 7 циклт үйл ажиллагаатай байна. Төсөлд суурилсан сургалтын явцад суралцагч хүүхэд залуучууд бодит амьдралын орчноос бий болсон энтрепренершип төслийг тогтсон циклийн дагуу боловсруулах, турших, үр дүнг дүгнэх, сайжруулах боломжтой болно.

Суралцагч бодит амьдрал дээрх аливаа асуудлыг өөрийн нүдээр олж тодорхойлон, асуудлыг шийдэх шийдлээ илрүүлэх, түүнийгээ төсөл болгон хэрэгжүүлэх санаагаа төсөөлөх, төслийн зорилгоо томъёолох, зорьсон санаагаа амьдралд хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулах зэрэг үйл ажиллагаа багтана.

Боловсруулсан төлөвлөгөөг төслийн санал, загварт оруулан дизайныг гаргана. Энэ нь зураг, график гэх мэт багаараа бүтээсэн тодорхой зүйл байх юм. Ялангуяа жишиг төсөл эсвэл загвартай байх нь их чухал бөгөөд хүмүүст нүдээр харж, биеэр мэдрэх, туршиж үзэх боломжийг олгодог. Жишиг төсөл эсвэл загвартай байвал энэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хэрэглэгчдэд танилцуулж, тэдний санал бодлыг сонсох, түүний дагуу сайжруулах боломжийг олгоно.

Суралцагчдад багаар хамтран төлөвлөсөн нөөц, санхүүжилтээ ашиглан тодорхой хугацаанд ажиллаж үр дүн, амжилтаа хэмжих, санаагаа бодитойгоор хэрэгжүүлэх боломж олдоно. Мөн тэд өөрсдийн таамаглал, шийдвэр, үйл хэргээ эргэн харж, юу амжилттай болсон, өөрөөр яаж хийх боломж байсан, бодит нөхцөл ямар байсныг дүгнэнэ.

Суралцагчийн зорилтот мэдлэг, чадвар, сэтгэлгээг зөвхөн сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэхэд хангалттай бус учраас багийн зохион байгуулалт, багийн оролцоо, чиг үүргээр дамжуулан хөгжүүлнэ.

Багууд МИНИ-ЭНТЕРПРАЙЗ компани хэлбэрийн зохион байгуулалттай байх ба багийн суралцагчид менежерийн тодорхой албан тушаалтай байна. Энэ нь суралцагчид дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээ хөгжих боломж олгоно. Үүнд:

- Албан тушаалын чиг үүрэг, компанийн ажил, зохион байгуулалтын талаарх мэдлэг
- Өөрийн хүчинд итгэх, цагийн менежментийн чадвар
- Идэвхтэй сонсох, асуулт асуух, санаагаа тайлбарлах, бусдын санааг ойлгох, үгээр болон бичгээр санал бодлоо илэрхийлэх
- Багаар ажиллах, нэгдсэн зорилгоо хамтдаа тодорхойлох, төлөвлөн зохион байгуулах
- Алдаанаас суралцах, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдлыг урьдчилан төлөвлөх, эргэцүүлэх

Сургалтын явцад суралцагч дараах үйл ажиллагаанд оролцоно. Үүнд:

- Бие даах ажил, кейс цуглуулах, дүн шинжилгээ, илтгэл, танилцуулга хийх
- Хос хосоороо болон багаар ажиллах, танхимаас гадуур суралцах
- Орон нутгийн аж ахуй, иргэдийн төлөөллийг сургалтад урилгаар оролцуулах
- Энтерпрайзын үйл ажиллагааг зохион байгуулах, МТ ашиглах



4.1 Чадамжийн нэгжийн жагсаалт

“Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн боловсролын 3 жилийн сургалтын төлөвлөгөөний 2 дахь жилд заавал судлах суурь чадамжаар тодорхойлогдоно.

д/д	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код
1	Мэргэжлийн англи хэл	BC 100-001
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах	BC 100-002
3	Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх	BC 100-003
4	Гамшгаас хамгаалах мэдлэг олгох	BC 100-004
5	Хөдөлмөрт бэлтгэх	BC 100-005

4.2 “Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” чадамжийн нэгжийн бүтэц

Чадамжийн нэгжийн нэр: Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх

Чадамжийн нэгжийн код: BC 100-003

Чадамжийн нэгжийн тодорхойлолт:

Энэхүү чадамжийн нэгжийн хүрээнд суралцагч өөрийн болон бусдын сэтгэл хөдлөл, түүний илрэх шинж, хувь хүний онцлогийг таньж мэдэх, тодорхойлох, цагийг оновчтой төлөвлөх, энтерпренершипийн оролцогч талуудыг тодорхойлох, энтерпренершипийн хэрэгцээ боломжийг илрүүлэх, энтерпрайз төсөл боловсруулах, энтерпрайз төслийн хэрэгжилтийн үйл явц, үр дүнг тандан судлах, шинэ төсөл боловсруулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, сэтгэлгээг эзэмшинэ.

Өмнө нь эзэмшсэн байвал зохих чадамжийн нэгж:

- Иргэний ёс зүйн боловсрол



Чадамжийн нэгжийн агуулгын төлөвлөлт:

№	Чадамжийн элемент	ГШҮ	Анги дүүргэлт: 24-28			
			Чадамжийн нэгжид ногдох цаг: 90			
			Танхимын		Танхимын бус	Чадамжийн элементэд ногдох цаг
			Онол	Дадлага		
1	ЭНТРЕПРЕНЕРШИП УР ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ	1.1 Сэтгэл хөдлөлөө таних	2	8	6	16
		1.2 Өөртөө итгэх итгэлтэй болох				
		1.3 Хамтрагчийн хувь хүний онцлогийг таних				
1.4 Гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаатай уялдуулан цагийг оновчтой төлөвлөх						
2	ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ	2.1 Энтрепренершипийн үндсэн ойлголтуудыг таних	2	4	4	10
		2.2 Асуудлыг оношлох, шинэ санаа боловсруулах				
		2.3 Энтрепренершипийн оролцогч талуудыг тодорхойлох				
3.1 Хувь хүний хүсэл, хэрэгцээг ялгах	6	8				
3.2 Тухайн орон нутгийн бүлэг нөхөрлөл, иргэдийн хэрэгцээг тандах, тодорхойлох						
3.3 Ялгаатай хэрэгцээг таних						
3.4 Хэрэгцээг хангаж буй туршлагыг илрүүлэх						
3.5 Өөрийн санааг гаргах, хөгжүүлэх						

4	ЭНТЕРПРАЙЗ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ	<p>4.1 Энтрепренершип санаа, бизнес загвар зураглах</p> <p>4.2 Бизнес загварыг хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх</p> <p>4.3 Санхүүгийн нөөцийг тооцоолох, хуваарилах</p> <p>4.4 Бизнес төлөвлөгөө боловсруулах</p> <p>4.5 Төслийг хэрэгжүүлэхэд тулгарах эрсдэлийг тодорхойлох, бууруулах арга замыг тооцоолох</p>	4	10	8	22
	ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦ, ҮР ДҮНГ ТАНДАН СУДЛАХ	<p>5.1 Энтерпрайз төслийн хэрэгжилтийг зохион байгуулах</p> <p>5.2 Энтерпрайз төслийн явц, үр дүнг тандах</p> <p>5.3 Төслийг үнэлж дүгнэх</p> <p>5.4 Төслийг сайжруулах</p>	2	2	6	10
	6	ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ	<p>6.1 Төсөл хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх</p> <p>6.2 Санхүүжилт авах шаардлагын дагуу төсөл боловсруулах</p> <p>6.3 Төслийн сонгон шалгаруулалтад оролцох</p> <p>6.4 Төслийн санааг хөгжүүлэх боломжийг тодорхойлох, тасралтгүй хөгжүүлэх</p>	2	4	6
Цагийн харьцаа			18	36	36	90
Онол, дадлагын цагийн харьцаа (хувиар)			20:80			

Тайлбар: Сургалтын 1 цагийг 40 минутаар тооцсон болно.

Гүйцэтгэлийн цар хүрээ, нөхцөл:

 <p>СУРГАЛТЫН ҮЕИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ ЖУРАМ</p>	<ul style="list-style-type: none"> • Орон нутаг болон бүлэг, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс судалгаа авч гадуур ажиллахад замын хөдөлгөөний аюулгүй байдал болон ХАБЭА-н дүрэм, журмыг чанд мөрдөж, өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал тавьж, шаардлагатай тохиолдолд мэдээлэл дамжуулах, эрсдэлд арга хэмжээ авч ажиллана. <ul style="list-style-type: none"> • Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм журам, стандарт • ХАБЭА-н дүрэм, журам • Кабинетын дүрэм • Аж ахуйн нэгж байгууллагын дотоод дүрэм, журам
 <p>АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЗААВАРЧИЛГАА</p>	<ul style="list-style-type: none"> • Экспансив суралцахуйн 7 циклт үйл ажиллагааны дагуу төсөлд суурилсан сургалтын арга зүйгээр суралцагч бодит амьдралын орчноос бий болсон энтрепренершип төслийг тогтсон циклийн дагуу боловсруулж, туршиж, үр дүнг дүгнэж, сайжруулна.
 <p>АЖЛЫН ХҮРЭЭНД ХАМТРАН АЖИЛЛАХ ХҮМҮҮС</p>	<ul style="list-style-type: none"> • Багш, ангийн багш • Сургалтын алба, сургуулийн удирдлага • Ментор, зөвлөх • Иргэд, олон нийт • Ангийн хамт олон, багийн гишүүд
 <p>ОРЧИН НӨХЦӨЛ</p>	<ul style="list-style-type: none"> • Онолын танхим • Компьютерын лаборатори • Дадлагын газар • Орон нутаг, дүүрэг, хороо, ААН, байгууллага

4.3 “Энтрепренершип ур чадвар хөгжүүлэх” чадамжийн элементийн төлөвлөгөө

Чадамжийн нэгжийн нэр	Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх
ЧЭ:1-н нэр	ЭНТРЕПЕНЕРШИП УР ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> 1.1 Сэтгэл хөдлөлөө таних 1.2 Өөртөө итгэх итгэлтэй болох 1.3 Хамтрагчийн хувь хүний онцлогийг таних 1.4 Гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаатай уялдуулан цагийг оновчтой төлөвлөх
Чадамжийн элементэд ногдох цаг	<p>Танхим: Онолын 2 цаг, дадлагын 8 цаг, нийт 10 цаг</p> <p>Танхим бус: Дадлагын 6 цаг</p> <p>ЧЭ-г нийт 16 цагаар төлөвлөсөн.</p>
Эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага	<p>Мэдлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн сэтгэл зүйн мэдлэг <p>Чадвар:</p> <ul style="list-style-type: none"> • Өөрийн хүчинд итгэх, өөрийгөө таних, сэтгэл хөдлөлөө тодорхойлох, хариу үйлдлээ мэдэх • Өөрийгөө бодитоор тодорхойлох, баг бүрдүүлэх, багаар ажиллах, багийн үүргээ тодорхойлох, харилцах • Цагийн менежмент болон стрессээ удирдах <p>Сэтгэлгээ, хандлага:</p> <ul style="list-style-type: none"> • Сэтгэлгээнийхээ онцлог, хэв шинжийг таньж мэдэх • Санаачилгатай байх
Сургалт явагдах орчин	<ul style="list-style-type: none"> • Онолын танхим • Компьютерын лаборатори
Сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт	<ul style="list-style-type: none"> • Багшийн гарын авлага, 2024 он • Суралцагчийн гарын авлага, 2024 он • Видео 1. Сэтгэл хөдлөл гэж юу вэ? https://www.youtube.com/watch?v=7UEBBR05IxM • Видео 2. Сэтгэл хөдлөлийг нэрлэцгээе! https://www.youtube.com/watch?v=ky0IwcX2Wgk&list=PLF-fUz8-4CDUN4DfajGwuIN0ZfMBoin7nr

	<ul style="list-style-type: none"> • Видео 3. Стресс менежмент https://www.youtube.com/watch?v=7Wf8n4BnXto&list=PLF-fUz8-4CDUN4DfajGwuIN0ZfMBoin7nr&index=3 • Видео 4. Үр дүнтэй багийн ажиллагаа https://www.youtube.com/watch?v=suQuKMvAxDc&list=PLF-fUz8-4CDUN4DfajGwuIN0ZfMBoin7nr&index=4 • Хичээлийн агуулгатай холбоотой бусад видео хичээл, хэвлэмэл материалууд
<p style="text-align: center;">Материал, түүхий эдийн жагсаалт</p>	<ul style="list-style-type: none"> • Флипчарт цаас • Маркер • Бал, балын харандаа • Өнгийн харандаа эсвэл фломастер • Бичгийн цаас • Скоч • Принтерийн хор
<p style="text-align: center;">Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт</p>	<ul style="list-style-type: none"> • Компьютер • Принтер • Ухаалаг дэлгэц эсвэл проектор • Проекторын дэлгэц • Уртасгагч, шилжүүлэгч • Яриа бичиж авах, зураг авах боломжтой гар утас (баг бүрд нэг байх)
<p style="text-align: center;">Ашигласан материал</p>	<ol style="list-style-type: none"> 1. “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” ЧСС-ын хөтөлбөр, 2024 он 2. “Багшийн гарын авлага”, 2024 он 3. “Суралцагчийн гарын авлага”, 2024 он
<p style="text-align: center;">Дүгнэлт:</p> <p>Энэ хэсэгт багш хичээл хэрхэн явагдсан талаар дүгнэлт хийнэ. (Ололт амжилт, алдаа дутагдал, ЧЭ-ийн агуулгыг сайжруулах шаардлагатай эсэх, хичээлийн цагийн хуваарилалт г.м.)</p>	

<p>Санал, зөвлөмж:</p> <p>Энэ хэсэгт багш, сургалтын албанаас ЧСС-ын хөтөлбөр, сургалтын орчныг хэрхэн сайжруулах, хичээлийн арга зүй болон хэрэглэгдэхүүний талаар санал, зөвлөмж бичиж үлдээнэ.</p>	
--	--

4.4 “Энтерпренершипийн оролцогч талуудыг тодорхойлох” чадамжийн элементийн төлөвлөгөө

Чадамжийн нэгжийн нэр	Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх
ЧЭ:2-н нэр	ЭНТРЕПЕНЕРШИПИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<p>2.1 Энтерпренершипийн үндсэн ойлголтуудыг таних</p> <p>2.2 Асуудлыг оношлох, шинэ санаа боловсруулах</p> <p>2.3 Энтерпренершипийн оролцогч талуудыг тодорхойлох</p>
Чадамжийн элементэд ногдох цаг	<p>Танхим: Онолын 2 цаг, дадлагын 4 цаг, нийт 6 цаг</p> <p>Танхим бус: Дадлагын 4 цаг</p> <p>ЧЭ-г нийт 10 цагаар төлөвлөсөн.</p>
